



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэ Ховд Жаргалант ТҮК ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/004/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2025 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: <a href="mailto:boldbaatarkh@audit.gov.mn">boldbaatarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: <a href="mailto:tsetsegsurena@audit.gov.mn">tsetsegsurena@audit.gov.mn</a> Аудитор: Н.Ариунтуяа Утас:70432545 Цахим хаяг: <a href="mailto:ariuntuyan@audit.gov.mn">ariuntuyan@audit.gov.mn</a></p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ШИНЭ ХОВД ЖАРГАЛАНТ ТҮК  
ОНӨААТҮГ-ЫН  
ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

2025.03.25 № 2/126

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинэ ховд жаргалант ТҮК ОНӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийг тус тус хуулийн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Аудитаар тус байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 2024 оны батлагдсан төсөв, төлөвлөгөө, ажилчдын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, үйл ажиллагааны үр ашгийн тооцооллыг боловсруулж хэлэлцүүлэн батлуулаагүй, батлагдсан төсөвгүй,
- Төвлөрсөн хогийн цэгийн талбайн хог түрж цэвэрлэхэд 8 аж ахуй нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулан нийт 23 удаагийн гүйлгээгээр 258,360.0 мянган төгрөгийг зарцуулсан нь гүйцэтгэсэн ажлын тайлан холбогдох анхан шатны баримт дутуу, гэрээг дүгнэж биелэлт тооцоогүй, жолоочийн тооцооны хуудас байхгүй;
- Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлт тооцоогүй, тушаал шийдвэргүй 3,052.5 мянган төгрөгийг олгосон;
- Нийгмийн даатгалын тайлан дээр үндсэн ажилтан биш тушаал шийдвэргүй хүнийг ажилтнаар бүртгэн нийгмийн даатгалын тайланг тайлагнасан;
- Тайлант оны эцэст 74,444.2 мянган төгрөгийн авлага, өглөгийг үүсгэсэн;
- Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй баримтаар 72,545.6 мянган төгрөгийг зарцуулсан зөрчил илэрсэн;

#### Асуудлыг онцолсон хэсэг

Ховд аймаг дахь Шинэ Ховд Жаргалант ТҮК ОНӨААТҮГ нь Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 1 дүгээр сарын 25 өдрийн 03 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмээ батлуулан, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг, нөлөөллийг бууруулах, Ховд хотын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхээр байгуулагдсан байна.

#### Аудитын гол асуудал

Тайлант онд хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээний ажилд орон нутгийн төсвөөс 901,784.2 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 856,592.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 195,165.3 мянган төгрөг, нийт 1,953,541.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,951,755.2 мянган төгрөгийн зардал санхүүжүүлэн ажилласан байна.

Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 11/07 дугаар тогтоолоор "нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тариф"-ийг хавсралтаар баталсан байна.

Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх м2-ийг 418 төгрөгөөр, энгийн хог хаягдлыг булшлах тонн 9131 төгрөгөөр тооцож, Ховд аймгийн Жаргалант сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 2/7/08 тогтоолоор энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх зардлыг нэгж тарифыг 15298 төгрөг байхаар тооцож баталсан ч төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлаагүй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. ☒☒

#### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

## 3.1 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	(төгрөгөөр)
			Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>146,205,498.61</u></b>	<b><u>111,854,007.35</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	205,798.61	1,992,318.35
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	205,798.61	1,992,318.35
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	205,798.61	1,992,318.35
31213	Арилжааны банк дахь харилцах	205,798.61	1,992,318.35
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	13,700,000.00	19,157,939.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	9,157,939.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	13,700,000.00	10,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	13,700,000.00	10,000,000.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	2,790,000.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	2,790,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	2,790,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	132,299,700.00	87,913,750.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	8,316,900.00
35110	Тусгай зориулалттай материал	-	8,316,900.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	132,299,700.00	79,596,850.00
35410	Бичиг хэргийн материал	357,500.00	1,019,000.00
35420	Аж ахуйн материал	6,323,700.00	3,896,750.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	593,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	67,200.00
35460	Хүнсний материал	1,163,900.00	2,137,500.00
35470	Бусад хангамжийн материал	124,454,600.00	71,883,400.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>769,012,055.61</u></b>	<b><u>829,328,280.88</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	769,012,055.61	829,328,280.88
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	768,308,930.69	828,859,530.99
39203	Авто-тээврийн хэрэгсэл	584,829,900.00	774,129,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(306,126,591.68)	(367,698,576.71)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,365,000.00	25,754,899.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,618,896.00)	(5,563,037.57)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	419,884,605.00	437,316,605.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,861,874.66)	(59,725,862.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	136,585,600.00	136,585,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(51,748,811.97)	(111,939,996.39)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	703,124.92	468,749.89
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(546,875.08)	(781,250.11)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>915,217,554.22</u></b>	<b><u>941,182,288.23</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>43,483,691.10</u></b>	<b><u>62,496,224.34</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	43,483,691.10	62,496,224.34
<b>413</b>	<b>Өглөг</b>	43,483,691.10	62,496,224.34

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	25,780,000.00	62,496,224.34
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>871,733,863.12</u></b>	<b><u>878,686,063.89</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	871,733,863.12	878,686,063.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	519,601,465.00	519,601,465.00
51101	Өмч: - төрийн	519,601,465.00	519,601,465.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	352,132,398.12	359,084,598.89
51210	Өмнөх үеийн үр дүн	352,132,398.12	352,132,398.12
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,952,200.77
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>915,217,554.22</u></b>	<b><u>941,182,288.23</u></b>

3.2.2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан  
(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,313,486,972.49</b>	<b>2,168,939,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>102,741,039.76</b>	<b>410,563,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	102,741,039.76	410,563,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,741,039.76	410,563,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,500,000.00	195,165,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	59,241,039.76	215,398,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,210,745,932.73</b>	<b>1,758,376,400.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,210,745,932.73	1,758,376,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	413,100,000.00	901,784,200.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	797,645,932.73	856,592,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>827,897,493.90</b>	<b>2,161,987,499.23</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>827,897,493.90</b>	<b>2,161,987,499.23</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	827,897,493.90	2,155,587,499.23
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	381,483,500.00	1,073,345,494.00
210101	Үндсэн цалин	381,483,500.00	834,993,523.00
210102	Нэмэгдэл	-	160,565,957.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	77,786,014.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	76,582,000.00	109,312,747.18
210201	Тэтгэврийн даатгал	76,582,000.00	76,095,757.78
210202	Тэтгэмжийн даатгал	-	8,952,442.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	5,072,740.29
210204	Ажилгүйдлийн даатгал	-	3,838,361.42
210205	Эрүүл мэндийн даатгал	-	15,353,445.60

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,856,000.00	13,577,237.00
210301	Гэрэл, цахилгаан	9,856,000.00	13,577,237.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	203,606,560.00	247,945,588.00
210401	Бичиг хэрэг	3,895,600.00	6,398,180.00
210402	Тээвэр, шатахуун	198,750,960.00	239,889,508.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	960,000.00	715,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	35,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		583,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	324,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	56,815,824.00
210502	Хоол, хүнс	-	39,925,824.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	16,890,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	37,428,198.83	41,188,080.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	37,428,198.83	38,815,040.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		2,373,040.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	11,891,800.00
210702	Дотоод албан томилолт	-	11,891,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	413,332,659.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	412,080,905.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	8,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	993,754.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	118,941,235.07	188,178,069.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		24,072,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,300,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	118,941,235.07	162,805,669.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	6,400,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	6,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,300,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>485,589,478.59</u></b>	<b><u>6,952,200.77</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>485,589,478.59</u></b>	<b><u>6,952,200.77</u></b>

## 3.3.2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,254,245,932.73</u></b>	<b><u>1,953,541,700.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>43,500,000.00</b>	<b>195,165,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	43,500,000.00	195,165,300.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	43,500,000.00	195,165,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	43,500,000.00	195,165,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,210,745,932.73</b>	<b>1,758,376,400.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,210,745,932.73	1,758,376,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	413,100,000.00	901,784,200.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	797,645,932.73	856,592,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,254,074,014.26</u></b>	<b><u>1,951,755,180.26</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,254,074,014.26</b>	<b>1,951,755,180.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,254,074,014.26</b>	<b>1,945,355,180.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	406,483,500.00	1,089,728,140.63
210101	Үндсэн цалин	406,483,500.00	1,089,728,140.63
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	125,680,394.13	40,000,000.00
210201	Тэтгэврийн даатгал	125,680,394.13	40,000,000.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,116,790.00	13,577,237.00
210301	Гэрэл, цахилгаан	12,116,790.00	13,577,237.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	493,066,160.00	263,859,878.00
210401	Бичиг хэрэг	3,895,600.00	5,999,900.00
210402	Тээвэр, шатахуун	289,650,560.00	239,889,508.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	960,000.00	726,800.00
210404	Ном, хэвлэл	-	670,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	198,560,000.00	16,573,670.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,850,000.00	78,194,304.00
210502	Хоол, хүнс	-	39,736,764.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,850,000.00	38,457,540.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	125,452,000.00	144,101,380.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	116,852,000.00	92,175,594.00
210602	Тавилга	-	20,817,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,600,000.00	21,803,036.00
210604	Урсгал засвар	-	9,304,850.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	10,541,800.00
210702	Дотоод албан томилолт	-	10,541,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	302,036,440.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	292,465,285.63
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	588,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	7,739,401.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	993,754.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	71,425,170.13	3,316,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,425,170.13	590,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,726,000.00

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>-</b>	<b>6,400,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>6,400,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,300,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>171,918.47</u></b>	<b><u>1,786,519.74</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	171,918.47	1,786,519.74
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	33,880.14	205,798.61
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	205,798.61	1,992,318.35

## 3.4.2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	519,601,465.00	-	(133,457,080.47)	386,144,384.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>519,601,465.00</b>	-	<b>(133,457,080.47)</b>	386,144,384.53
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	485,589,478.59	485,589,478.59
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>519,601,465.00</b>	-	<b>352,132,398.12</b>	871,733,863.12
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>519,601,465.00</b>	-	<b>352,132,398.12</b>	871,733,863.12
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>519,601,465.00</b>	-	<b>352,132,398.12</b>	871,733,863.12
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	6,952,200.77	6,952,200.77
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>519,601,465.00</b>	-	<b>359,084,598.89</b>	<b>878,686,063.89</b>

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар залруулагдаагүй нийт 430,246.7 мянган төгрөгийн 5 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар 2 албан шаардлага, 430,246.7 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>1</sup> илэрсэн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгсөн.

### 3.1 Албан шаардлага

#### 3.1.1 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шинэ Ховд Жаргалант ТҮК ОНӨҮГ -ын үйл ажиллагааны орлогын доод, зарлагын дээд хязгаар, ашиг хуваарилах, орон тоо, цалингийн санг ТУЗ-ийн хурлын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга хянаж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн мэдүүлж жил бүр баталж, биелэлтэд хяналтыг хэрэгжүүлэн ажиллана гэж дүрэмдээ заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулах, аймгийн ИТХ-ын 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангаагүй, эрх үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

#### 3.1.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Шилэн дансны нэгдсэн [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим сайтын тулгалтаар дараа жилийн төсвийн төсөл, төсвийн байгууллагын төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, 5 сая төгрөгөөс дээших санхүүжилтийн орлого, төсвийн хэмнэлт хэтрэлтийн шалтгаан тайлбарыг байршуулаагүй, санхүүгийн тайлан хагас жилээр, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг мэдээллүүдийг байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; 6.1.2-д хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор; 6.1.3-д дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; 6.1.5-д төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор; 6.1.6-д төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр; Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 Зөвлөмж

#### 3.2.1 Ур чадварын нэмэгдэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Ур чадварын тушаалыг байгууллагын дарга өөрөө өөртөө тушаал гарган олгосон, үр дүнгийн нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төлөөлөн удирдах зөвлөлөөр төсөв төлөвлөгөө, цалин хөлс нэмэгдэл урамшууллыг хэлэлцүүлэн батлуулах

#### 3.2.2 Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүйтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд 2024 онд төвлөрсөн хогийн цэгийн талбайн хог түрж цэвэрлэхэд 8 аж ахуй нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулан нийт 23 удаагийн гүйлгээгээр 258,360.0 мянган төгрөгийг зарцуулсан нь гүйцэтгэсэн ажлын тайлан болон холбогдох анхан шатны баримтаар нотлогдоогүй гэрээг дүгнэж биелэлт тооцоогүй, бусад анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй баримтаар 72,545.7 мянган төгрөг нийт 330,905.6 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжүүлэн анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангаж, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд байгууллагын дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах

#### 3.2.3 Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Авлага, өр төлбөрийн дэлгэрэнгүй бүртгэлийг тооцоо нийлсэн акттай тулган шалгахад тайлант оны ажил гүйгээ, гэрээ хэлцлийн хүрээнд бий болсон бусдаас авах авлага, өр төлбөрийн тооцоо нь 74,444.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Он дамжсан насжилт өндөртэй авлага, өглөгийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулан барагдуулах.

#### 3.2.4 Нийгмийн даатгалын тайлан тайлагнахтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд нийгмийн даатгалын тайлан дээр үндсэн ажилтан биш тушаал шийдвэргүй хүнийг ажилтнаар бүртгэн 2024 оны 07 дугаар сараас 12 дугаар сарыг дуустал 17,246.4 мянган төгрөгийг нийгмийн даатгалын тайланд тайлагнасан зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй

ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нийгмийн даатгалын байцаагчтай тооцоо нийлж, нийгмийн даатгалын тайланг анхан шатны баримтад үндэслэн залруулга хийж, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх.

### 3.2.5 Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Жаргалант сумаас шилжиж ирсэн мотоциклийг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй, Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2024 оны 6 дугаар сарын 4-ны А/46 дугаар захирамжийн хавсралтыг мөрдөөгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хөрөнгийг 2025 онд орлогод авч данс бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Шинэ ховд Жаргалант ТҮК ОНӨҮГазар	Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар 2024 оны батлагдсан төсөв, төлөвлөгөө, ажилчдын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, үйл ажиллагааны үр ашгийн тооцооллыг батлуулаагүй.	1	-		-	1	0					
	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй.	1				1	0					
	Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй, хувь хүн, аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулсан ч гэрээ дүгнээгүй, биелэлт тооцоогүй, жолоочийн тооцооны хуудас бодоогүй, тооцоо бодсон акт үйлдээгүй	1	330,905.6						1	330,905.6		
	Ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэр шалгуур үзүүлэлт тооцоогүй олгосон	1	3,052.5						1	3,052.50		
Авлага, өглөгийг барагдуулаагүй	1	74,444.2						1	74,444.20			

	Нийгмийн даатгалын тайланг зөрүүтэй тайлагнасан	1	17,246.4				1	17,246.40			
	Хөрөнгө орлогод авч данс бүртгэлд тусгаагүй	1	4,598.0				1	4,598.00			
	<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>430,246.70</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>5</b>	<b>430,246.7</b>	<b>0</b>	<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨҮГазар	1	1				1		
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		